



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/36

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолоор баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 2.16, 2.17 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Мөнхжаргал (Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Золжаргал (Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)  
Г.Нэмэхбаяр (Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга)  
Л.Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: И.Хатанболд (Нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч)

2.Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэмд заасны дагуу зохион байгуулж, томилох эрх бүхий этгээдэд саналыг хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (С.Мөнхжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР